



**“БАГАХАНГАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

**Ажил дүгнэх журамд өөрчлөлт
оруулах тухай**


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолын 3 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Багахангайн Үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8, Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.4 дэх заалт, Байгууллагын даргын 2020 оны А/18 дугаар тушаалын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Албан хаагчдын үр дүнгийн нэмэгдэл олгох журмын 3.1 “Ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ажлын үр дүнгийн нэмэгдэл улирал бүр олгоно” гэж заасныг “Хөдөлмөрийн тухай хуулийн 43.1.3 дахь заалтыг үндэслэн ажилтныг шагнаж урамшуулах, 3.2 Үр дүнгийн нэмэгдлийг тухайн сард бодогдсон цалингийн “40” гэснийг үндсэн цалингийн “50” хүртэл хувиар тооцон олгох, 4.5 Шалгуур 6 үзүүлэлтийн үнэлгээг 90-100 оноог маш сайн, 70-90 хүртэл оноог “Хэвийн”, 70 хүртэл оноог Хангалтгүй” 3 үнэлгээний ангилалд хамруулан, урамшуулал олгох хувийг “Хэвийн” үнэлгээний ангилалд хамрагдсан албан хаагчийн мөнгөн урамшууллын хэмжээ нь “Маш сайн” ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хүртэл хувьтай тэнцүү байна гэж тус тус өөрчилсүгэй.

2. Албан хаагчдын үр дүнгийн нэмэгдэл олгох журмыг албан хаагчдад танилцуулж, журмын хэрэгжилтийг ханган хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа, хүний нөөцийн менежер (Ц.Оюунтөгс)-т даалгасугай.

3. Өөрчлөлт орсон албан хаагчдын үр дүнгийн нэмэгдэл олгох журмыг 2023 оны 12 дугаар сараас мөрдөн, зохих хууль, журмын дагуу нэмэгдлийг тооцож олгохыг Нягтлан бодогч (Г.Батням)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ЖАМБАЛЦЭРЭН